



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/07

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг хэсэгчлэн
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Багаа овогт Шарын Цэндмаа нь Шивээговь сум 1 дугаар баг, 15 дугаар байрны зүүн талд байрлах “Автомашины гараж”-ийн зориулалттай 84м² газрын эзэмших эрхийг хэсэгчлэн шилжүүлэх хүсэлт гаргасан тул хавсралтад заагдсан иргэдэд “Автомашины гараж”-ийн зориулалтаар анх авсан этгээдийн үлдсэн хугацаагаар тооцон шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Монгол Улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэдэд үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрхийг хуулийн дагуу хэсэгчлэн шилжүүлэн авч буй хавсралтад заагдсан иргэдтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Баярмагнай)-д үүрэг болгосугай.


4.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2019 оны А/193 дугаар захирамжийн 16 дахь бүртгэлийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

42124 014



Сумын Засаг даргын 2024 оны
01-р сарын 12-ны өдрийн 1107 дугаар
захирамжийн хавсралт



Эзэмших эрхийг хэсэгчлэн шилжүүлж авч буй иргэдийн жагсаалт

Д/д	Иргэдийн нэр	Регистрийн дугаар	Хугацаа /жил/	Газрын хэмжээ /м2/	Багийн дугаар	Газрын байршил	Газрын зориулалт
1	Багаа овогт Шарын Цэндмаа	ЗЮ73100380	10	42	1	15-р байрын зүүн талд	Автомашин гараж
2	Баяд овогт Сампильн Бумжаргал	ЕЙ70010824	10	42	1	15-р байрын зүүн талд	Автомашин гараж
Нийт				84			